



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 02. 23 № 358

танай _____-ны № _____-т

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газар хооронд байгуулсан "Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр" 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс нь тайлант онд 5 зорилт, 8 хөтөлбөр, 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, зорилт, арга хэмжээний биелэлт 94.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/383/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн захирал: Ш.Ичинхорлоо
Утас: 99102291 Цахим хаяг: ichinhorloo@gmail.com

Аудитын менежер: И.Туяа
Утас: 99298711 Цахим хаяг: Tuyaishjamts@gmail.com

Аудитор: С.Удвал Цахим хаяг: udval@gmail.com

Аудитыг гүйцэтгэсэн: Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК
Утас: 77820808 Цахим хаяг: NITS Audit

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын тайлан.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт.....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ЖБАТ	Жирэмсэний болон амаржсаны тэтгэмж
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,697,142,546.48	15,613,427,696.22
	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,141,047,780.18	5,106,407,557.34
	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,141,047,780.18	5,106,407,557.34
	Төгрөг	3,141,047,780.18	5,106,407,557.34
31211	Төрийн сангийн харилцах	4,574,377.07	99.65
31213	Арилжааны банк дахь харилцах	3,136,473,403.11	5,106,407,457.69
	АВЛАГА	13,535,592,806.80	10,472,462,377.38
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	12,918,487,789.06	9,592,649,202.58
33300	Татаас, санхүүжилтийн авлага	507,353,156.87	354,621,599.02
33510	Байгууллагаас авах авлага	109,751,860.87	525,191,575.78
	БАРАА МАТЕРИАЛ	20,501,959.50	34,557,761.50
	Хангамжийн материал	20,501,959.50	34,557,761.50
35410	Бичиг хэргийн материал	1,916,800.00	6,600,180.00
35420	Аж ахуйн материал	15,390,644.50	25,447,094.50
35430	Сэлбэг хэрэгсэл	678,020.00	678,020.00
35470	Бусад хангамжийн материал	2,516,495.00	1,832,467.00
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	639,898,391.15	602,839,761.92
	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	639,898,391.15	602,839,761.92
	Биет хөрөнгө	609,198,391.15	572,139,761.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	574,275,555.00	569,475,555.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(51,046,912.81)	(57,590,009.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	8,235,000.00	8,235,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,058,750.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	68,273,089.38	62,666,242.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,862,429.40)	(26,485,661.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,676,100.00	56,156,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,352,011.02)	(38,258,714.31)
	Биет бус хөрөнгө	30,700,000.00	30,700,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	30,700,000.00	30,700,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,337,040,937.63	16,216,267,458.14
	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,332,749.74	240,433,751.84
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,332,749.74	240,433,751.84
	Өглөг	6,804,220.98	16,397,768.04
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,804,220.98	16,397,768.04
	Урьдчилж орсон орлого	13,528,528.76	224,035,983.81
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	13,528,528.76	224,035,983.81
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,316,708,187.89	15,975,833,706.29
	Засгийн газрын хувь оролцоо	358,519,215.05	358,519,215.05
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	336,114,363.39	336,114,363.39

	Хуримтлагдсан үр дүн	16,958,188,972.84	15,617,314,491.24
51210	Өмнөх үеийн үр дүн	16,958,188,972.84	16,958,188,972.84
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,340,874,481.60)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	22,404,851.66	22,404,851.66
	ӨР ТӨЛӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	17,337,040,937.63	16,216,267,458.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	46,977,155,947.49	52,111,364,191.90
	ТАТВАРЫН ОРЛОГО	26,186,683,808.18	32,226,177,799.97
	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	26,186,683,808.18	32,226,177,799.97
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	17,602,817,995.73	21,693,669,654.64
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,855,862,468.81	2,283,733,400.01
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,174,703,022.01	2,629,953,905.19
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	370,489,913.06	457,766,168.69
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	4,182,810,408.57	5,161,054,671.44
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,599,694.31	479,739,525.68
	Нийтлэг татварын бус орлого	73,599,694.31	479,739,525.68
120002	Хүүгийн орлого	-	27,171,180.90
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	37,669,841.52	14,587,451.71
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,235,641.52	11,227,740.11
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	151,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,283,200.00	3,359,711.60
120009	Бусад орлого	35,929,852.79	437,980,893.07
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,716,872,445.00	19,405,446,866.25
	Улсын төсвөөс	6,296,566,807.00	7,626,028,182.25
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,296,566,807.00	7,626,028,182.25
	Төсвийн захирагчдаас	13,995,084,638.00	11,159,776,584.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,995,084,638.00	11,159,776,584.00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	425,221,000.00	619,642,100.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	417,923,600.00	619,642,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,297,400.00	-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	46,329,316,950.33	53,452,238,673.50
	УРСГАЛ ЗАРДАЛ	46,329,316,950.33	53,452,238,673.50
	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	402,627,643.98	606,091,090.92
	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	291,962,135.21	398,973,611.25
210101	Үндсэн цалин	188,017,422.86	235,047,561.31
210102	Нэмэгдэл	42,501,624.00	64,077,831.99

210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,427,452.00	44,992,633.27
210104	Урамшуулал	28,015,636.35	54,855,584.68
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,035,485.84	51,631,347.39
210201	Тэтгэврийн даатгал	25,467,368.44	34,839,417.37
210202	Тэтгэмжийн даатгал	2,999,028.11	4,217,155.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,303,115.13	3,346,789.18
210204	Ажилгүйдлийн даатгал	522,225.95	854,854.18
210205	Эрүүл мэндийн даатгал	5,743,748.21	8,373,131.65
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,830,974.43	20,094,382.65
210301	Гэрэл, цахилгаан	2,743,369.53	3,615,826.22
210302	Түлш, халаалт	10,775,010.10	15,175,996.43
210303	Цэвэр, бохир ус	1,312,594.80	1,302,560.00
	Хангамж, бараа материалын зардал	11,676,473.35	15,228,260.80
210401	Бичиг хэрэг	4,553,350.00	5,748,720.00
210402	Тээвэр, шатахуун	2,641,200.00	1,633,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,167,085.85	3,894,906.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	331,400.00	503,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	983,437.50	3,149,750.00
210408	Бараа материал акталсны зардал	-	298,384.00
	Эд хогшил, урсгал засварын зардал	741,000.00	54,455,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	241,000.00	1,200,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	53,255,000.00
	Томилолт, зочны зардал	48,000.00	3,784,000.00
210702	Дотоод албан томилолт	48,000.00	3,784,000.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,634,467.00	20,138,148.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,900,400.00	6,063,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,600,000.00	11,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	649,971.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,752.00	91,752.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	286,000.00
210807	Газрын төлбөр	92,100.00	92,100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,698,280.00	1,995,352.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	601,964.00	409,444.00
	Бараа үйлчилгээний бусад зардал	30,699,108.15	41,786,340.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,368,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	335,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	30,364,108.15	40,418,340.83
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,926,689,306.35	52,846,147,582.58
	Бусад урсгал шилжүүлэг	37,153,914,425.00	45,107,821,157.25
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	37,130,009,986.00	45,103,635,746.25
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,511,900.00	4,185,411.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,209,053.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	183,486.00	-
	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,772,774,881.35	7,738,326,425.33
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,772,774,881.35	7,738,326,425.33
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	647,838,997.16	(1,340,874,481.60)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	46,374,476,964.75	55,427,763,296.76
	ТАТВАРЫН ОРЛОГО	24,586,310,278.05	35,582,346,060.60
	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	24,586,310,278.05	35,582,346,060.60
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	16,525,814,156.54	23,945,065,745.25
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,743,666,743.26	2,524,894,403.19
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,039,106,871.22	2,905,463,457.20
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	346,496,966.20	509,089,280.39
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	3,931,225,540.83	5,697,833,174.57
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	309,543,486.70	79,112,952.16
	Нийтлэг татварын бус орлого	309,543,486.70	79,112,952.16
120002	Хүүгийн орлого	-	23,332,669.60
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	309,543,486.70	55,780,282.56
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	309,392,486.70	55,780,282.56
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	151,000.00	-
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	21,478,623,200.00	19,766,304,284.00
	Улсын төвлөрсөн төсвөөс	7,088,702,500.00	7,987,393,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,088,702,500.00	7,987,393,400.00
	Төсвийн захирагчдаас	13,964,699,700.00	11,159,268,784.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,964,699,700.00	11,159,268,784.00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	425,221,000.00	619,642,100.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	417,923,600.00	619,642,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,297,400.00	-
	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	46,390,359,694.96	53,462,403,519.60
	УРСГАЛ ЗАРДАЛ	46,390,359,694.96	53,462,403,519.60
	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	372,960,654.33	579,220,752.09
	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	291,962,135.21	398,973,611.25
210101	Үндсэн цалин	188,017,422.86	235,047,561.31
210102	Нэмэгдэл	42,501,624.00	64,077,831.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,427,452.00	44,992,633.27
210104	Урамшуулал	28,015,636.35	54,855,584.68

	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,035,485.84	51,631,347.39
210201	Тэтгэврийн даатгал	25,426,997.44	34,839,417.37
210202	Тэтгэмжийн даатгал	2,999,028.11	4,217,155.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,345,403.13	3,346,789.18
210204	Ажилгүйдлийн даатгал	571,442.87	854,854.18
210205	Эрүүл мэндийн даатгал	5,692,614.29	8,373,131.65
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,830,974.43	20,094,382.65
210301	Гэрэл, цахилгаан	2,743,369.53	3,615,826.22
210302	Түлш, халаалт	10,775,010.10	15,175,996.43
210303	Цэвэр, бохир ус	1,312,594.80	1,302,560.00
	Хангамж, бараа материалын зардал	12,297,535.85	28,735,706.80
210401	Бичиг хэрэг	4,298,050.00	9,498,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,641,200.00	1,633,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,167,085.85	3,894,906.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	331,400.00	503,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,859,800.00	13,206,200.00
	Эд хогшил, урсгал засварын зардал	1,419,020.00	54,455,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	919,020.00	1,200,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	53,255,000.00
	Томилолт, зочны зардал	48,000.00	3,784,000.00
210702	Дотоод албан томилолт	48,000.00	3,784,000.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,032,503.00	20,178,704.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,900,400.00	6,513,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,600,000.00	11,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	649,971.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,752.00	91,752.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	286,000.00
210807	Газрын төлбөр	92,100.00	92,100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,698,280.00	1,995,352.00
	Бараа үйлчилгээний бусад зардал	335,000.00	1,368,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,368,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	335,000.00	-
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,017,399,040.63	52,883,182,767.51
	Бусад урсгал шилжүүлэг	37,244,624,159.28	45,144,856,342.18
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	37,157,571,288.29	45,103,498,246.25
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,511,900.00	4,185,411.00
213205	Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, урамшуулал	63,148,431.99	37,172,684.93
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн менген тэтгэмж	20,209,053.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	183,486.00	-

	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,772,774,881.35	7,738,326,425.33
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,772,774,881.35	7,738,326,425.33
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(15,882,730.21)	1,965,359,777.16
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(15,882,730.21)	1,965,359,777.16
ЭХ.ДТ(31)	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,156,930,510.39	3,141,047,780.18
ЭЦ.ДТ(31)	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,141,047,780.18	5,106,407,557.34

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	336,114,363.39	22,404,851.66	16,337,921,470.17	16,696,440,685.22
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-27,571,494.49	-27,571,494.49
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	336,114,363.39	22,404,851.66	16,310,349,975.68	16,668,869,190.73
3	Талант оны үр дүн			647,838,997.16	647,838,997.16
	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	336,114,363.39	22,404,851.66	16,958,188,972.84	17,316,708,187.89
6	2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	336,114,363.39	22,404,851.66	16,958,188,972.84	17,316,708,187.89
8	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,340,874,481.60)	(1,340,874,481.60)
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	336,114,363.39	22,404,851.66	15,617,314,491.24	15,975,833,706.29

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,256,342,400.00	45,686,904,409.34	1,569,437,990.66	97.0
	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	47,256,342,400.00	45,686,904,409.34	1,569,437,990.66	96.7

21	III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДВН	47,256,342,400.00	45,686,904,409.34	1,569,437,990.66	97.0
210	Бараа, ажил вйлчилгээний зардал	618,819,200.00	579,220,752.09	39,598,447.91	93.6
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	422,838,500.00	398,973,611.25	23,864,888.75	94.0
210101	Үндсэн цалин	220,909,400.00	235,047,561.31	-14,138,161.31	106.4
210102	Нэмэгдэл цалин	74,430,400.00	64,077,831.99	10,352,568.01	86.1
210103	Унаа, хоолны хөнгөлөлт	59,532,000.00	44,992,633.27	14,539,366.73	75.6
210104	Үр дүнгийн урамшуулал	67,966,700.00	54,855,584.68	13,111,115.32	80.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,854,800.00	51,631,347.39	1,223,452.61	98.0
210201	Тэтгэврийн даатгал	35,941,300.00	34,839,417.37	1,101,882.63	97.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,300,400.00	4,217,155.01	83,244.99	98.1
210203	ҮОМШ өвчний даатгал	3,339,500.00	3,346,789.18	-7,289.18	100.
210204	Ажилгүйдлийн даатгал	888,900.00	854,854.18	34,045.82	96.2
210205	ЭМ-ийн даатгал	8,384,700.00	8,373,131.65	11,568.35	100.
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,254,800.00	20,094,382.65	6,160,417.35	76.5
210301	Гэрэл цахилгаан	6,569,700.00	3,615,826.22	2,953,873.78	55.0
210302	Түлш, халаалт	17,548,000.00	15,175,996.43	2,372,003.57	86.0
210303	Цэвэр, бохир ус	2,137,100.00	1,302,560.00	834,540.00	60.9
2104	Хангамж, бараа материалын зардал	30,509,800.00	28,735,706.80	1,774,093.20	94.2
210401	Бичиг хэрэг	10,223,600.00	9,498,100.00	725,500.00	93.0
210402	Тээвэр (шатахуун)	2,174,300.00	1,633,100.00	541,200.00	75.1
210403	Шуудан, холбоо, интернетийн зардал	4,018,900.00	3,894,906.80	123,993.20	97.0
210405	Хог хаягдал зайлуулах, устгал, ариутгал	808,000.00	503,400.00	304,600.00	62.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс	13,285,000.00	13,206,200.00	78,800.00	99.4
2106	Эд хогшил, урсгал засврын зардал	55,905,400.00	54,455,000.00	1,450,400.00	97.4
210601	Багаж, хэрэгсэл	2,405,400.00	1,200,000.00	1,205,400.00	50.0
210604	Урсгал засвар	53,500,000.00	53,255,000.00	245,000.00	99.5
2107	Томилолт, зочны зардал	5,431,800.00	3,784,000.00	1,647,800.00	70.0
210702	Дотоод албан томилолт	5,431,800.00	3,784,000.00	1,647,800.00	70.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, вйлчилгээний хөлс, төлбөр хураамж	23,074,100.00	20,178,704.00	2,895,396.00	87.4

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, вйлчилгээний төлбөр хураамж	6,815,000.00	6,513,500.00	301,500.00	95.6
	Мэдээллийн технологийн вйлчилгээний хөлс	320,000.00	286,000.00	34,000.00	89.0
210802	Аудит, зэрэглэл тогтоох вйлчилгээний хөлс (дотоод)	11,200,000.00	11,200,000.00	0.00	100.0
210803	Тээврийн хэрэгслийн даатгал	580,000.00	0.00	580,000.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	91,752.00	58,248.00	61.2
210807	Газрын төлбөр	98,000.00	92,100.00	5,900.00	94.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын вйлчилгээний хураамж	3,911,100.00	1,995,352.00	1,915,748.00	51.0
2109	Бараа, вйлчилгээний бусад зардал	1,950,000.00	1,368,000.00	582,000.00	70.1
210901	Бараа, вйлчилгээний бусад зардал	1,500,000.00	1,368,000.00	132,000.00	91.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	450,000.00	0.00	450,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,633,324,200.00	45,103,498,246.25	1,529,825,953.75	96.7
2132	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардал	46,633,324,200.00	45,103,498,246.25	1,529,825,953.75	96.7
213201	Өндөр насны тэтгэвэр	33,054,496,400.00	32,269,727,331.00	784,769,069.00	98.0
213202	Тахир дутуугийн тэтгэвэр	3,003,333,100.00	2,757,200,529.00	246,132,571.00	91.8
213203	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	1,339,429,800.00	1,234,778,275.00	104,651,525.00	92.0
213204	Цэргийн албан хаагчийн тэтгэвэр	3,814,567,800.00	3,625,508,455.25	189,059,344.75	95.0
213205	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	590,770,800.00	486,435,067.00	104,335,733.00	82.0
213206	Оршуулгын тэтгэмж	422,000,000.00	266,000,000.00	156,000,000.00	63.0
213207	Жирэмсэний болон амаржсаны тэтгэмж	945,942,500.00	1,098,707,293.00	-152,764,793.00	116.0
213208	ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	2,703,798,900.00	2,336,729,628.00	367,069,272.00	86.4
213209	Ажилгүйдлийн тэтгэмж	757,086,000.00	1,028,411,668.00	-271,325,668.00	136.0
	НДШ-ийн илүү төлөлтийн буцаан олголт	1,898,900.00	0.00	1,898,900.00	0.0

213204	Ажил олгогчоос олгох тэтгэмж, нэг удаагийн урамшуулал, дэмжлэг	4,199,000.00	4,185,411.00	13,589.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР:	47,256,342,400.00	45,686,904,409.34	1,569,437,990.66	97.0
1340	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	39,268,949,000.00	37,699,511,009.34	1,569,437,990.66	96.0
	Төсвөөс санхүүжих	7,987,393,400.00	7,987,393,400.00	0.00	100.0
	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0
	АЖИЛЛАГСАД БҮГД	20.00	19.00	1.00	95.0
	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	0.00	100.0
	Үйлчлэх ажилтан	3.00	2.00	1.00	67.0
	Гэрээт ажилтан	0.00	0.00	0.00	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Тус байгууллага эрхэм зорилгоо “Даатгуулагчдын нийгмийн баталгааг хангах, хууль ёсны эрхийг хамгаалах нийгмийн даатгалын үйлчилгээг тогтвортой, чанартай хүргэхэд оршино” гэж тодорхойлж, “Даатгуулагчдын нийгмийн баталгааг хангах, хууль ёсны эрхийг хамгаалах нийгмийн даатгалын үйлчилгээг тогтвортой, чанартай хүргэх” зорилт дэвшүүлсэн байна. Зорилтын хүрээнд дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллажээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;
- Нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого зарлагын гүйцэтгэлийг хангах;
- Нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах;
- Улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

НДЕГ-ын даргын 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/22 дугаар тушаалаар Хэлтсийн дарга 1, Үйлчилгээний тасаг 10, Санхүү бүртгэлийн тасаг 7, Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг 2, нийт 20 орон тоог баталсан бөгөөд 2023 онд 19 орон тоотойгоор ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ –ын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн чуулганаар баталсан Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль,
- МУЗГ-ын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай”, 238 дугаар Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай 239 дүгээр тогтоол;
- МУЗГ-ын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоол;
- МУЗГ-ын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 241 дүгээр тогтоол;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай” А/01 дүгээр тушаалаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан;
- Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 60 дугаар тогтоол;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн “Даатгуулагчийн төрлийн код шинээр батлах тухай” А/36 дугаар, 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн “Даатгуулагчийн төрлийн код шинээр батлах тухай” А/43 дугаар тушаал”;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай” А/136 дугаар тушаал;
- Гадаад харилцааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/69, А/132 дугаар хамтарсан тушаал “Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээг батлах тухай”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод хяналт шалгалтын тасгаас 2023 оны 4 дүгээр улирлын ажлын тайланд шалгалт хийгдсэн бөгөөд бусад дээд шатны болон мэргэжлийн хяналтын байгууллагуудаас шалгалт хийээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/65 дугаар тушаалаар баталсан харьяа байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,120,773.4 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,141,047.8	5,106,407.5	1,965,359.7
Авлага	13,535,592.8	10,472,462.4	-3,063,130.4
Бараа материал	20,501.9	34,557.8	14,055.9
Үндсэн хөрөнгө	639,898.4	602,839.8	-37,058.6
Нийт хөрөнгө	17,337,040.9	16,216,267.5	-1,120,773.4
Өр төлбөр	20,332.8	240,433.7	220,100.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	358,519.2	358,519.2	0.00
Хуримтлагдсан үр дүн	16,958,188.9	15,617,314.5	-1,340,874.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	17,337,040.9	16,216,267.44	-1,120,773.4

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данстууд байна.

Мөнгөн хөрөнгө 5,106,407.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба өмнөх оноос 1,965,359.7 мянган төгрөгөөр буюу 38.5 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Нийгмийн даатгалын сангуудын зарцуулагдаагүй үлдэгдэл 530,470.2 мянга, 2024 оны 1 дүгээр сарын тэтгэвэр, тэтгэмжид олгохоор хуримтлуулсан 4,575,937.3 мянган төгрөг байна.

Авлага өмнөх оноос 10,472,462.4 мянган төгрөг болж, 3,063,130.4 мянган төгрөгөөр буюу 29.2 хувиар буурсан нь 2023 онд хугацаа хэтрүүлсэн шимтгэлийн өр төлбөртэй аж ахуйн нэгж, байгууллагуудын шимтгэлийг барагдуулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран ажиллаж, өр төлбөрийг барагдуулах ажлын төлөвлөгөөг сар бүр гарган ажилласан нь тодорхой үр дүнд хүрчээ. Авлагын дансанд 1-2 жилийн насжилттай 4,879,983.2 мянган төгрөг, 5 дээш жилийн насжилттай 5,592,479.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 34,557.8 мянган төгрөг болж 14,055.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 25,987.4 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 507.8 мянга, нийт 26,495.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 12,439.4 мянган төгрөгийн материал зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 602,839.8 мянган төгрөг болж 37,058.6 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 809 дүгээр тогтоолоор үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлснээр үнэ төлбөргүй хүлээн авсан 3,359.7 мянган төгрөг нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 826 дугаар тогтоолыг үндэслэн акталж, устгасан 17,286.5 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хассанаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 240,433.7 мянган төгрөг болж, 220,100.9 мянган төгрөгөөр өссөн нь дээд шатны байгууллагаас урьдчилж орсон орлоготой холбоотой байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 1,340,874.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төслийн саналд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 42,149,004.0 мянга, нийгмийн даатгалын сангаас 452,546.8 мянга, нийт 42,601,550.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг НДЕГ-ын даргын 2023 оны А/04 дүгээр тушаалаар 42,601,550.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн тодотголоор батлагдсан төсөвт зардлыг 4,654,791.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 47,256,342.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 7,987,393.4 мянга, нийгмийн даатгалын сангаас 39,268,949.0 мянган төгрөгийг тус тус бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 7,987,393.4 мянга, нийгмийн даатгалын сангаас 37,699,511.0 мянган, нийт 45,686,904.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд 581,582.3 мянга, нийгмийн даатгалын сангийн зардалд 45,105,322.1 мянган төгрөгийг зарцуулж, 1,569,438.0 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны нийт зардлын гүйцэтгэл 581,582.3 мянган төгрөг буюу 93.8 хувьтай байна.

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын гүйцэтгэл 45,105,322.1 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байгаа нь 1,531,378.2 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/
Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
80101	Үндсэн үйл ажиллагааны урсгал зардал	580,553.1	545,222.4	35,328.9	93.9
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	7,425.0	6,688.3	736.7	90.0
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	2,000.0	1,750.0	250.0	87.5
80213	Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээ	400.0	353.5	46.5	88.3
80219	Харуул хамгаалалтын зардал	3,965.0	3,960.0	5.0	99.8
80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	21,100.0	19,422.8	1,679.1	92.2
80813	Хуульд заасан үндэслэлээр алба	1,300.0	1,290.6	9.3	99.2
80820	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,899.0	2,894.7	4.2	99.8
	Нийт дүн	619,642.1	581,582.3	38,059.8	93.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төвлөрүүлэлтийн талаар:

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд зааснаар нийт 46,636,700.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого төвлөрүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 45,105,322.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, шимтгэлийн орлого 3.3 хувиар тасарсан байна.

Орлогын төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал: /Мянган төгрөгөөр/

Сангийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэвэрт	41,211,827.1	39,887,214.5	1,324,612.6	96.8
Тэтгэмж	1,958,713.3	1,851,142.5	107,570.8	94.5
ҮОМШӨ	2,703,798.9	2,336,729.6	367,069.3	86.4
Ажилгүйдэл	757,086.0	1,028,411.7	-271,325.7	135.8

НДШ-ийн илүү төлөлтийн буцаан олголт	1,898.9	-	1,898.9	100.0
Бараа, үйлчилгээний бусад зардал	3,376.1	1,823.8	1,552.3	54.0
Нийт дүн	46,636,700.3	45,105,322.1	1,531,378.2	96.7

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, санд 2023 онд нэмэлт төсөв, санхүүжилт олгоогүй байна.

3.5.5.Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн худалдан авалтыг НДЕГ-аас хариуцан гүйцэтгэдэг тул худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэл гаргаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын нийгмийн даатгалын сангийн зарцуулалт, үндсэн хөрөнгийн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Алтанхундага, аудитор С.Удвал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, НТАГ-ын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 46,329,316.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 694,939.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, түлш халаалт, цахилгаан, бичиг хэрэг, томилолтын зардлыг хэтрүүлэхгүй байх талаар анхаарч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг судалгаанаас харахад дэд дарга, орлогч дарга, зөвлөх албан тушаалын орон тоогүй, дуудлагын автомашин ашигладаггүй, албан тушаалын автомашин хэрэглэдэггүй, төсвийн хөрөнгөөр дүрэмт хувцас болон бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй, чиг үүрэг, орон тоог давхардуулаагүй, бараа материал их хэмжээгээр нөөцлөөгүй, нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашигласан, бичиг хэрэг, албан томилолтын зардлыг хэмнэхэд анхаарч ажилласан байна.

Байгууллагын даргын 2023 оны Б/30 тоот тушаалаар нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас байгууллагын ажилтны хуримын ёслолд 500.0 мянган төгрөгийг олгож, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. "Төсвийн байгууллага, ТБОНӨ-т хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 14 төрлийн 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2023 онд нийт 581,582.3 мянган төгрөгийн 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 503,188.5 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийгмийн даатгалын сан нь нийт 45,105,322.1 мянган төгрөгийн 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 122,267.9 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Шилэн дансны цахим системд хөрөнгө мөнгө зарцуулах тухай 625,456.4 мянган төгрөгийн 7 шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4. "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ." 6.4.5. "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" 6.4.8. "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулж, биелэлтийг ирүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАУХАТХ хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг түүвэрлэн үзэхэд материаллаг хэмжээний зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцэж байна гэж дүгнэлээ

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хамруулж, 5 дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар нийт 33,571.8 мянган төгрөгийн 5 алдаа илрүүлснээс 26,139.3 мянган төгрөгийн 3 зөрчилд өгсөн зөвлөмжийг аудитын явцад 100.0 хувь хэрэгжүүлж,

7,432.5 мянган төгрөгийн 2 алдаа байгааг жилийн эцсийн аудитын тайланд зөвлөмж өгөв.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,614.5 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснийг 99.0 хувиар хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	3,614.5	2	3,614.5	99.0
Нийт дүн	3	3,614.5	2	3,614.5	99.0

Шилэн дансны цахим хуудсанд 159 мэдээлэл байршуулахаас 8 мэдээлэл байршуулаагүй алдаа дахин давтагдсан тул жилийн эцсийн аудитаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн шинж чанарыг агуулсан 9,194.6 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансад бүртгэснийг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,194.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулаагүй тул дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 424,090.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 424,090.5 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тэтгэврийн даатгалын сангийн данснаас жирэмсний болон амаржсаны тэтгэмжид 152,764.8 мянга, ажилгүйдлийн тэтгэмжид 271,325.7 мянган төгрөгийг тус тус шилжүүлэн зарцуулсан нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д "Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, нэгтгэх, зориулалт бусаар ашиглахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1.2 Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлж зарцуулахгүй байх.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн шинж чанарыг агуулсан хөрөнгө 8,804.6 мянган төгрөгийг аж ахуйн материалын дансанд, 390.0 төгрөгийг сэлбэг хэрэгслийн дансанд тус тус бүртгэж, тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д: "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дансанд 9,194.6 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 20-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн	2	9,194.6							2	9,194.6	2	9,194.6
Дүн	2	9,194.6							2	9,194.6	2	9,194.6

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
НД-ын сан хооронд зарцуулсан	1	424,090.5					1	424,090.5				
Дүн	1	424,090.5					1	424,090.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
			Төлбөрийн акт		Албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлбэл зохих 14 төрлийн 116 мэдээллээс 4 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	1	625,456.4			1	625,456.4		
Дүн	1	625,456.4			1	625,456.4		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төсвийг зориулалт бус зарцуулсан	1	500.0	1	500.0				
Дүн	1	500.0	1	500.0				
Нийт дүн	2	625,956.4	1	500.0	1	625,456.4		



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 дугаар сарын 23

№ 21/21725351

Улаанбаатар хот

НТАГ-2024/383/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас байгууллагын ажилтны хуримын ёслолд 500,000.00 (таван зуун мянга) төгрөгийг олгож, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. "Төсвийн байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3. "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилтанд олгосон дэмжлэгийн 500,000.00 (таван зуун мянга) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 31-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Р.Өнөржаргал, ахлах нягтлан бодогч О.Отгончимэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН1:

ЭН АЙ ТИ ЭС БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

АУДИТОР

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА,

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХЯНАСАН:



Ш.ИЧИНХОРЛОО

С.УДВАЛ

Х.ТҮВШИНБАЯР

Я.АЛТАНЦЭЦЭГ

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 99/21725351

Улаанбаатар хот

ИТНС-2024/383/НА-СТА-ТМС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлбэл зохих 14 төрлийн 159 мэдээллээс 150 мэдээллийг цаг хугацаанд байршуулж, 503,188,500.0 (таван зуун гурван сая нэг зуун наян найман мянга таван зуу) төгрөгийн 7 мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10. "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим системд хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Р.Өнөржаргал, ахлах нягтлан бодогч О.Отгончимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:

ЭН АЙ ТИ ЭС БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ш.ИЧИНХОРЛОО

АУДИТОР

С.УДВАЛ

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

ХЯНАСАН:

Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ



1 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002042603